



МОНГОЛ УЛСЫН
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ
ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН
ТОГТООЛ

2018 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13.5.1, 13.6-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах тооллогын Улсын комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.


2. Улсын комисст мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, тооллогыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Үндэсний статистикийн хороо /А.Ариунзаяа/-нд үүрэг болгосугай.

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН
УЛСЫН КОМИССЫН ДАРГА,
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



УХҮРЭЛСҮХ

0000002



**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ
ЯВУУЛАХ ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Улсын комиссын анхдугаар хурлыг зохион байгуулах <u>Хэлэлцэх асуудал:</u> А. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын талаар товч танилцуулга Б. Улсын комиссын хийх үйл ажиллагааны төлөвлөгөө В. Аймаг, нийслэлийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай	2018 оны II сар	УК-ын дарга
2	Улсын комиссын Нарийн бичгийн даргыг томилж ажиллуулах	II сар	УК-ын орлогч дарга, ҮСХ-ны дарга
3	Улсын комиссын тамга, албан бичиг, тогтоолын бланк хэвлүүлэх	II сар	УК-ын орлогч дарга, ҮСХ-ны дарга
4	Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого /цаашид ХАОСТ-2020 гэх/-ын зардлын тооцоог боловсруулах	I-II сар	УК-ын орлогч дарга, ҮСХ-ны дарга
5	Байшин, орон сууцны 2019 оны тооллого /цаашид БОСТ-2019/-ын туршилтын тооллогын асуулга зааврыг боловсруулах, нарийвчилсан төлөвлөгөө гаргах, бэлтгэлийг хангах	I-III сар	УК-ын орлогч дарга, ҮСХ-ны дарга, УК-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд
6	ХАОСТ-2020-ын мастер төлөвлөгөөг боловсруулах	II-IV сар	УК-ын орлогч дарга, ҮСХ-ны дарга
Тооллого зохион байгуулж явуулах бүтцийг бий болгох			
7	Байшин, орон сууцны тооллого зохион байгуулж явуулах яамны салбар комиссыг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах	III сар	УК-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд
8	Хилийн болон дотоодын цэргийн алба хаагчид, хоригдож буй сэжигтэн, яллагдагчийн тооллогыг зохион байгуулж явуулах яамны салбар комиссуудыг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах	IV сар	УК-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд
9	Хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын тооллогыг зохион байгуулж явуулах яамны салбар комиссыг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах	IV сар	УК-ын гишүүн, Батлан хамгаалахын сайд

10	Гадаадад түр болон байнга оршин суугаа Монгол Улсын иргэдийн тооллогыг зохион байгуулах тооллогын салбар комиссыг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах	IV сар	УК-ын гишүүн, Гадаад харилцааны сайд
11	Сум, дүүрэг, баг, хороонд тооллого зохион байгуулж явуулах тооллогын комисс, түр товчоог байгуулах ажлыг удирдан чиглүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах	IV сар	УК-ын орлогч дарга нар, УК-ын гишүүн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
Ойлголт, тодорхойлолт, ангилал, аргачлалыг нийцрүүлэх			
12	Холбогдох сэдэв, үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, ангилал, кодыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлах. Үүнд: <ul style="list-style-type: none"> Барилга, байшин, орон сууцны асуудлаарх ойлголт, тодорхойлолт, ангилал, код Ус хангамж, ариутгах татуургын ойлголт, тодорхойлолт, ангилал, код 	III сар	УК-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд
13	Холбогдох сэдэв, үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, ангилал, кодыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлах. Үүнд: <ul style="list-style-type: none"> Цахилгааны эх үүсвэрийн ангилал, код, ойлголт, тодорхойлолт Халаалтын эх үүсвэрийн ангилал, код, ойлголт, тодорхойлолт 	III сар	УК-ын гишүүн, Эрчим хүчний сайд
14	Холбогдох сэдэв, үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, ангилал, кодыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлах. Үүнд: <ul style="list-style-type: none"> Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, код, ойлголт, тодорхойлолт Ажил, мэргэжил болон албан тушаалын ангилал 	II-IV сар	УК-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
15	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай нийцүүлэн оршин суугчид нь хотын хүн амд хамаарах хот, тосгон бусад суурин газрын жагсаалтыг нэрээр гаргах	II-IV сар	УК-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд УК-ын орлогч дарга, ҮСХ-ны дарга
16	Холбогдох сэдэв, үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, ангилал, кодыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлах. Үүнд: <ul style="list-style-type: none"> Боловсролын түвшний ангилал, код, ойлголт, тодорхойлолт 	II-IV сар	УК-ын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд

	<ul style="list-style-type: none"> • Үндэстэн, угсаатны ангилал, код, ойлголт тодорхойлолт • Шашны ангилал, код, ойлголт тодорхойлолт 		
17	<p>Холбогдох сэдэв, үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, ангилал, кодыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлийн ангилал, код, ойлголт, тодорхойлолт 	II-IV сар	УК-ын гишүүн, Эрүүл мэндийн сайд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
Бүртгэлд суурилсан тооллогын бэлтгэлийг хангах			
18	<p>Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн өрх, хүн амын үзүүлэлтүүдийн бүрэн нөхөлт, мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг сайжруулахад тогтмол хяналт тавьж, чиглэл өгч ажиллах</p>	I-X сар	УК-ын орлогч дарга нар, УК-ын гишүүн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч
19	<p>Холбогдох мэдээллийн сан дахь мэдээллийн үнэн бодит байдлыг ханган шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төв суурин газрын кадастрын зураг, тоон мэдээллийн сан • Кадастрын мэдээллийн сан • Хаягийн мэдээллийн сан • Барилга, орон сууцны болон бусад шаардлагатай мэдээллийн сан 	I-IV сар	УК-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд
20	<p>Холбогдох мэдээллийн сан дахь мэдээллийн үнэн бодит байдлыг ханган, шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Иргэний бүртгэл, мэдээллийн улсын сан • Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын мэдээллийн сан • Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэдийн бүртгэлийн сан • Монгол Улсын харьяат болсон болон харьяатаас гарсан иргэдийн мэдээллийн сан • Хилийн болон дотоодын цэргийн алба хаагчид, хоригдож буй сэжигтэн, яллагдагчийн мэдээллийн сан 	I-X сар	УК-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд
21	<p>Холбогдох мэдээллийн сан дахь мэдээллийн үнэн бодит байдлыг ханган, шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдын мэдээллийн сан 	I-X сар	УК-ын гишүүн, Батлан хамгаалахын сайд

22	<p>Холбогдох мэдээллийн сан дахь мэдээллийн үнэн бодит байдлыг ханган шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Асрамжийн газарт байгаа иргэдийн судалгаа • Хүүхдийн асрамжийн газарт байгаа иргэдийн судалгаа • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа • Нийгмийн даатгалын мэдээллийн сан • Халамжийн мэдээллийн сан • Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдын мэдээллийн сан • Өрхийн амжиргааны түвшний цахим мэдээллийн сан 	I-X cap	УК-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
23	<p>Холбогдох мэдээллийн сан дахь мэдээллийн үнэн бодит байдлыг ханган, шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагчдын мэдээллийн сан • Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын мэдээллийн сан • Их, дээд сургуульд суралцагчдын мэдээллийн сан 	I-X cap	УК-ын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
24	<p>Холбогдох мэдээллийн сан дахь мэдээллийн үнэн бодит байдлыг ханган, шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн мэдээллийн сан 	I-X cap	УК-ын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд
25	<p>Холбогдох мэдээллийн сан дахь мэдээллийн үнэн бодит байдлыг ханган, шинэчилж, тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Цахилгаан хэрэглэгчдийн мэдээллийн сан • Дулаан хэрэглэгчдийн мэдээллийн сан 	I-X cap	УК-ын гишүүн, Эрчим хүчний сайд